



## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилан зарцуулж, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл эзэлж, сангидад тавих хяналт хангалтгүй байна.

АГУУЛГА

<p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p><b>Нийтлэг үндэслэл</b> Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилан зарцуулсан ч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.</p>
<p><b>Тайланг бэлтгэсэн:</b> <i>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор</i></p>	<p>1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэл болон бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл, хувь хэмжээгээр төлөвлөсөн байна.</p>
<p><i>Л.Ламаачин</i> <b>Аудитын менежер</b> <i>Д.Гансух</i></p>	<p>1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар зарцуулсан байна.</p>
<p><b>Ахлах аудитор</b> <i>Ц.Отгонням</i> <b>Аудитор</b> <i>П.Хорлоосүрэн</i></p>	<p>1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавиагүй, Сангийн яаманд үр дүнгийн тайланг хүргүүлээгүй байна.</p>
<p><b>2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр</b></p>	<p>1.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-ын 12, 58 дугаар зүйлийн 4-ийн 3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.</p>
<p><b>Хоёрдунд олон мянган тооны бус зөвлөлийг байгуулсан ч зарим сумд хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.</b></p>	<p><b>Хоёр. Сум хөгжүүлэх санд тавих хяналт хангалтгүй, хариуцлага тооцдоггүйгээс нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна</b></p>
<p><b>Үг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></b></p>	<p>2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хангалтгүй, зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн тооцож төвлөрүүлээгүй байна.</p>
<p><b>Аудитын тайлан, дүгнэлтийн холбоотой асуудлаар нэмж тодруулах, асуух лавлах зүйл байвал 70323108 дугаарын утас, 70323253 дугаарын факсаар харилцана уу</b></p>	<p>2.2 Сум хөгжүүлэх сангаар нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна.</p>
<p><b>ХАЯГ:(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баатар Нутгийн удирдлагын ордон 402 тоот)</b></p>	<p>2.3 Сум хөгжүүлэх санд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулсан ч зарим сумд хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.</p>
<p><b>Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Зөрчлийн нэгтгэл Албан шаардлага Аудитын хавсралт маягтууд</b></p>	<p>2.4 Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогdon гарсан хууль журам төдийлөн мөрдөгдөхгүй, сангийн үйл ажиллагаа нь зорилго, зорилтдоо хүрэхгүй байгаа нь хууль, эрх зүйн асуудлыг өөрчлөх шаардлагатайг харуулж байна.</p>
<p><b>Гурав. Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.</b></p>	<p>Гурав. Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.</p>
<p><b>3.1 Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, зарим албан шаардлага хэрэгжээгүй байна.</b></p>	<p>3.1 Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, зарим албан шаардлага хэрэгжээгүй байна.</p>
<p><b>3.2 СХС-ийн өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.</b></p>	<p>3.2 СХС-ийн өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.</p>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	<i>Улсын Их Хурал</i>
АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
ҮАГ	<i>Үндэсний аудитын газар</i>
НАГ	<i>Нийцлийн аудитын газар</i>
НА	<i>Нийцлийн аудит</i>
АГ	<i>Аудитын газар</i>
СЯ	<i>Сангийн яам</i>
ХХААХҮЯ	<i>Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам</i>
ОНХНС	<i>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
СХС	<i>Сум хөгжүүлэх сан</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
ИТХТ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
ТЭЗҮ	<i>Техник эдийн засгийн үндэслэл</i>
ГХБХБГазар	<i>Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар</i>
СТСХ	<i>Санхүү төрийн сангийн хэлтэс</i>
СХДАХ	<i>Санхүүгийн хяналт дотоод аудитын хэлтэс</i>
ШШГАлба	<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба</i>
ЖДҮХМэргэжилтэн	<i>Жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн</i>
TAX	<i>Төсөл арга хэмжээ</i>
ОНӨААТҮГ	<i>Орон нутгийн өмчийт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</i>
ТБОНӨХБАУХАТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль</i>
ЗД	<i>Засаг дарга</i>
ХХК	<i>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</i>

## Нийтлэг үндэслэл

### *Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:*

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнтын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өвөрхангай аймгийн 2017 оны ОНХСан, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж гүйцэтгэв.

### *Аудитын зорилт:*

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГазарт хүргүүлэн, УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

### *Аудитын хамрах хүрээ:*

Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлagnal, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлagnalыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгав.

### *Аудитад хэрэглэсэн арга зүй:*

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын

төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

***Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:***

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”.

***Аудитын стандартын талаарх мэдэгдэл:***

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын нийцлийн аудитын багийн ахлах аудитор Ц.Отгонням, аудитор П.Хорлоосүрэн нар 2018 оны 09 дүгээр сарын 14-ээс 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитаар нийт 3964.8 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ - Нэг.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилан зарцуулсан ч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.

**1.1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл, хувь хэмжээгээр төлөвлөсөн байна.**

**1.1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг орон нутагт үзэх боломжгүй байна.**

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт орон нутагт үзэх боломжгүй байна.

**1.1.1.2. ОНХС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн эсэхийг орон нутагт үзэх боломжгүй байна.**

Орон нутгийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийг Сангийн яаманд тооцож байгаа тул орон нутагт үзэх боломжгүй байна.

**1.1.1.3. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр төлөвлөсөн байна.**

Өвөрхангай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь буюу 598.4 сая төгрөг, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь буюу 920.3 сая төгрөг, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь буюу 381.8 сая төгрөг, Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулал 353.4 сая төгрөг нийт 2253.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

**1.1.2 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг болон эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд зааснаар бүрдүүлсэн байна.**

**1.1.2.1 ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд зааснаар бүрдүүлсэн байна.**

Сангийн яамнаас 2017 оны ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59.1<sup>1</sup> -д зааснаар 2253.9 сая төгрөгөөр баталсан байна.

<sup>1</sup> Төсвийн тухай хуулийн 59.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;

59.1.3.орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

### 1.1.2.2 Аймаг сумын ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59.1<sup>2</sup> -д зааснаар бүрдүүлсэн байна.

Сангийн яамнаас 2017 онд Өвөрхангай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь буюу 598.4 сая төгрөг, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь буюу 920.3 сая төгрөг, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь буюу 381.8 сая төгрөг, Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулалт 353.4 сая төгрөг нийт 2253.9 сая төгрөгөөр баталсан байна.

### 1.1.3 ОНХСанг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

#### 1.1.3.1 Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

Тус аймаг Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасныг 672.1 сая төгрөгөөр, 59.2.2-д заасан санхүүжилтийг 721.9 сая төгрөгөөр, 59.2.3-д заасныг 859.8 сая төгрөгөөр тус тус тооцон ОНХС-аас олгосон хөрөнгийг хуваарилан баталсан байна.

#### 1.1.3.2 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2-д “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо алслалт нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэж заасны дагуу аймаг орон нутгийн хөгжлийн сангаас 1581.7 сая төгрөгийн 45.6 хувь буюу 721.9 сая төгрөгийг сумдад, 54.4 хувь буюу 859.8 сая төгрөгийг аймагт Төсвийн тухай хуулийн 59.3-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан итгэлцүүрээр хуваарилан тооцож, төлөвлөсөн байна.

#### 1.1.3.3 ОНХС болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны төсөв баталсан, төсөвт өөрчлөлт оруулсан тогтоолуудыг олгосон санхүүжилттэй харьцуулан дараах хүснэгтээр харуулав.

<sup>2</sup> Төсвийн тухай хуулийн 59.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;

59.1.3.орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулалт, дэмжлэг;

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ  
САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Хүснэгт 1 (сая төгрөгөөр)

	Сумын нэр	Батлагдсан төсөв(2016-12-01 ны 03/06)	Тодотгосон төсөв (2017-05-08 ны 04/03)	Тодотгосон төсөв (2017-11-03 ны 05/01)	Олгосон санхүүжилт	Зөрүү
1	Баян-өндөр	20.80	10.74	15.23	15.23	-
2	Бүрд	30.22	42.00	35.17	35.17	-
3	Бат-Өлзий	44.77	59.15	46.44	46.44	-
4	ББУлаан	16.83	8.83	18.80	18.80	-
5	Баянгол	15.75	8.32	16.47	16.47	-
6	Гучин-Ус	15.83	30.64	45.17	41.17	4.00
7	Есөнзүйл	11.67	22.62	33.07	29.07	4.00
8	Өлзийт	11.57	22.42	31.42	31.42	-
9	ЗБУлаан	14.38	7.66	15.17	15.17	-
10	Богд	32.83	16.51	33.86	23.86	10.00
11	Нарийнтээл	35.78	48.52	43.63	43.63	-
12	Сант	12.41	24.01	35.40	35.40	-
13	Тарагт	19.00	31.51	38.64	38.64	-
14	Төгрөг	17.75	33.09	47.07	41.86	5.21
15	Уянга	41.88	20.86	20.50	20.50	-
16	Хдулаан	16.82	30.80	43.62	39.62	4.00
17	Хужирт	16.94	30.09	41.16	37.16	4.00
18	Хархорин	22.74	41.11	59.29	49.29	10.00
19	Арвайхээр	40.06	70.81	101.87	81.87	20.00
20	Аймгийн ОНХсанд	1,022.06	1,022.06	859.80	926.10	-
59.2.2	Мал эмнэлэгийн үйлчилгээ	434.46	434.46	434.46	434.46	-
дахь	Сумын Мал эмнэлэг	36.89	36.89	36.89	36.89	-
заалт	Арвайхээр хот тохиижилт үйлчилгээ	200.77	200.77	200.77	200.77	-
	<b>Дүн</b>	<b>2,132.2</b>	<b>2,253.9</b>	<b>2,253.9</b>	<b>2,259.0</b>	<b>61.2</b>

Дээрх хүснэгтээс хараад Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэд 2017 онд 2 удаа төсвийн тодотгол хийжээ. Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсвөөс аймгийн ОНХС-д Гучин-Ус, Есөнзүйл, Богд, Төгрөг, Хайрхандулаан, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдын ОНХС-ийн хөрөнгөөс нийт 61.2 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

## 1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар зарцуулсан байна.

**1.2.1 Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталж ажилласан байна.**

**1.2.1.1 Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.**

Аймаг, сумдын ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймаг, сумдын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Сум болгон эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг /2012-2022 он/ гэх мэтээр 10 жилээр төлөвлөж, энэ дагуу төсөл арга хэмжээг уялдуулан төлөвлөж ажиллажээ.

**1.2.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдээд нээлттэй хэлэлцүүлэн санал авч байгаа боловч төсвийн хүрэлцээ багассан, урд онуудын саналын эрэмбэлэлтээр хийгдээгүй ажлууд хойшилсноос иргэдээс авах санал багассан байна.<sup>3</sup>**

Аймаг, сумдын 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сангийн хөрөнгөөр хийх ажлын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсгийг аймаг, сумдад байгуулан ажиллуулсан байна.

Аймаг, сумдын Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн урьдчилсан саналын жагсаалтыг Төсвийн тухай хууль, журмын дагуу боловсруулан иргэдээс багуудын ИНХ-ын үеэр саналыг авч хэлэлцүүлсэн байна.

Сумдууд ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдээс санал авах маягтаар болон олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж, багуудын ИНХ-аар хэлэлцүүлэн саналыг тэргүүлэх ач холбогдол бүхий орон нутагт тулгамдсан асуудлуудыг эрэмбэлэн сумын ИТХ-ын тогтоол гарган ажиллажээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн нийт 160 төсөл арга хэмжээний 34 нь урд оноос шилжиж ирсэн, 126 төсөл арга хэмжээг шинээр санхүүжүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээ 30 хувийг нь эзэлж байгаа тул төсөл арга хэмжээнд иргэдийн саналын эрэмбэлэлт урьд оноос багассан байна.

**1.2.1.3 Аймаг, сумдын Засаг дарга баг, хороодоос ирсэн саналыг хууль тогтоомжид тавьсан шаардлагын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгасан байна.**

Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн санал авч нэгдсэн жагсаалтыг гарган багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолоор батлан эрэмбэлсэн саналыг сумын ЗДТГ тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж төсвийн төсөлд тусган сумын ИТХ-аараа батлан хэрэгжүүлж байгаа боловч зарим сүм нийт иргэдээ санал авах ажиллагаанд бүрэн хамруулах ажил дутагдалтай байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн санал аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээ”<sup>4</sup> гэж заасныг зөрчин аймгийн төвийн Ахмадын өргөөний барилга угсралтын ажил, Төгрөг сумын

<sup>3</sup> Төсвийн тухай хуулийн 63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.



63.2.Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэпцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.


63.3.Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сүм, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сүм, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

<sup>4</sup> Төсвийн тухай хуулийн 60.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах эүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

ЗДТГ-ЫН барилгын их засварын ажлын зураг төсвийн ажил иргэдийн саналаар дэмжигдээгүй, багуудын ИНХ-аар хэлэлцүүлэн санал авалгүй эрэмбэлж баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэдийн оролцоог санал асуулгаар авч дүнг дараах графикаар харуулав.





#### 1.2.1.4 "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан TAX-г хэрэгжүүлсэн байна.<sup>5</sup>

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн байна.

Сумд ОНХС-аар хийгдэх ажлын ихэнхийг харьцуулалтын болон шууд худалдан авах, олон нийтийн оролцооны аргаар зохион байгуулж, төсөв тооцоо, үнэлгээг Үнэлгээний хорооноос гаргаж, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, ажлын гэрээнд тусгаж өгсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөгдсөн томоохон ажлын ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн байна. Тухайлбал: Аймгийн Ахмадын хорооны зураг төслийг баталсан, холбогдох байгууллагуудаас техникийн тодорхойлолт, нөхцөлийг гаргуулсан байна.

Харин Богд суманд баригдсан Хуурай сүүний үйлдвэрийн барилгын зураг байгаа боловч ТЭЗҮ болон төсөвгүй, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээгүй ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

<sup>5</sup> "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалт Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх.

**1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан байна.**

**1.2.2.1. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.**

Аймгийн үнэлгээний хорооны гишүүд бүгд худалдан авах ажиллагааны чиглэлийн сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Тендерийн урилга, мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “e-procurement.mof.gov.mn”, “procurement.ov.gov.mn”, “uvurkhangai.mn” сайтууд болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болох Зууны мэдээ сонин, мэдээллийн самбараар мэдээллээ байршуулсан байна.

Тендерийн баримтаас үзэхэд аймаг, сумд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, Тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналууд, тендерийг хянан үзэх, маягтуудыг хөтөлжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн аймгийн төвд шинээр баригдах Ахмадын өргөөний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Харин Арвайхээр сумын 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн захирамжаар 10.7 сая төгрөгийн өртөгтэй аймгийн төвийн наадмын талбайн засварын ажлыг Арвайхээр сумын тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Д.Сүх-Өлзийд эрх шилжүүлсэн боловч шууд гэрээ байгуулан ажил гүйцэтгэсэн байна.

Төгрөг сумын гар худгийн засвар үйлчилгээ хийх ажлыг олон нийтийн оролцооны аргаар зохион байгуулах үнэлгээний хороог сумын Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 28 ны өдрийн А/66 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Богд сумын Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн а/82 дугаар захирамжаар Хуурай сүүний үйлдвэрийн барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Уг үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ байхгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.6<sup>6</sup>-д заасан шаардлагыг хангахгүй байна.

Үнэлгээний хороо 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хуралдан Хуурай сүүний үйлдвэрийн 44.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлыг харьцуулалтын аргаар шуурхай зарлах санал гарган тендерийн баримт бичиг боловсруулан зарласан байна. ТБОНӨХБАҮХАТХуулийн 21 дүгээр зүйлд заасан “Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх”<sup>7</sup> шаардлагыг хангахгүй байна. Тус тендерийн материалыг олгох тухай 3 компани

<sup>6</sup> ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.6. Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна

<sup>7</sup> ТБОНӨХБАҮХАТХуулийн 21.1. Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

21.2. Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

хүсэлт ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийг тус компаниудад өгсөн эсэх нь тодорхойгүй байлаа. Үнэлгээний хороо 2017 оны 08 дугаар сарын 03 ны өдөр хуралдаж нэг ч компани тендерийн материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах аргыг сонгохоор шийдвэр гаргасан байна. Сумын засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 08 ны өдрийн a/92 дугаар захирамжаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг хүчингүй болгож шууд гэрээ байгуулах шийдвэр гаргаж Смарт зоос ХХК-тай Хуурай сүүний үйлдвэрийн барилга барих ажлыг 2017 оны 08 дугаар сарын 28- ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд гүйцэтгэх 44.0 сая төгрөгийн төсөвтэй гэрээ байгуулсан байна.

**1.2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас тавьж, Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс, сумдын төрийн сангүүд төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгож ирсэн байна.**

Аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГазраас ОНХС-аар хийгдэж буй барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьж ирсэн байна. Үүнд:

- Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явцад хяналт тавьсан, 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ажил хүлээлцэх комисс ажилласан хуралдааны тэмдэглэл хөтөлсөн байна.
- Арвайхээр сумын Ахмадын өргөө хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын явцад 4 удаа хяналт тавьж үүрэг даалгавар өгч ажилласан бөгөөд 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг захирамжаар байгуулан, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ирсэн байна. Тухайлбал: Бат-Өлзий, Баянгол, Есөнзүйл, Богд, Төгрөг, Хужирт, Гучин-Ус, Нарийнтээл сумд ажлын хэсэг байгуулан ажлын явцад хяналт тавьж ажилласан байна.

Богд сумын засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн a/15 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилон, үйлдвэрийн барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссын акт үйлдсэн байна. Барилгын ажлыг хүлээн авах комиссын гишүүний саналаар 95 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн боловч барилгын ажлыг хүлээн авсан байна. Барилгын ажлыг аудитаар газар дээр очиж үзэхэд шал цутгаагүй, тусгаарлах хана чийгтэй, эмульс халтартсан чанар байдлын хувьд хангалтгүй байлаа. Тус барилгын ажлын тоо хэмжээ, хяналтын төсөв хийж батлуулаагүй гэрээг байгуулсан учир гүйцэтгэгчийн дутуу ажлыг харах боломжгүй байна.



Зураг 1: ТЭЭҮ-гүй чанаргүй гүйцэтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээний 11 дүгээр зүйлд “Мах сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулах арга хэмжээний 4-р зорилтын 33-р заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Орон нутгийн нөөцийг ашиглах, сүүг эдийн засгийн эргэлтэд оруулах “Монгол хуурай сүү” төслийг хамтран хэрэгжүүлэх заалтын дагуу тус Сүүний үйлдвэрийн барилгын ажил хүлээлцээд жил болж байхад үйлдвэр одоог хүртэл ашиглалтад ороогүй байгаад тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

#### 1.2.2.3. ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, журмын дагуу зарцуулжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг төсвийн жилийн хугацаанд санхүүжилт багассан, хугацаандаа хийгдэхгүй байгаагаас “Төсвийн тухай хууль”-ийн 59.2 дахь заалт зөрчигдэж байна. Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг “Төсвийн тухай хууль”-ийн 59.2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тогтоолын дагуу тооцож сумдад олгож байгаа боловч төсвийн орлого бүрдүүлэлт, санхүүжилтээс шалтгаалан оны эхнээс сумдад жигд хуваарилан олгохгүй оны эцсээр санхүүжилт очдогоос шалтгаалан сумдын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ, тайлант жилдээ хэрэгжихгүй он дамжсан өр авлага үүсэж байна.

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зориулалт бусаар зарцуулсан зөрчил гарсан байна. Тухайлбал:

- Бүрд суманд Цагдаагийн мотоцикл авахад 2.0 сая төгрөг
- Төгрөг суманд Ахмадын жилийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах зардалд 0.5 сая төгрөгийг медалийн үнэд шилжүүлсэн.
- Нарийнтээл сумын Бизнес хөгжлийн төвийн барилгын цонх солих ажил Бат угсралт констракшин ХХК –тай 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдөр ОНХС 01/2017 гэрээг байгуулжээ. Гэвч төлбөрийн хүсэлтээр санхүүжилтийг 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдөр 2.6 сая төгрөг, 7.5 сая төгрөг, нийт 10.1 сая төгрөгийн санхүүжилт гэрээ байгуулахаас өмнө олгож Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 , Засгийн

газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.13.7 -д заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### 1.2.2.4. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

Сумууд ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна. Харин Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 851.5 сая төгрөгийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтад оруулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй байна.



Зураг 2: Бүртгэлд тусгаагүй барилга.

#### 1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавиагүй, Сангийн яаманд үр дүngийн тайланг хүргүүлээгүй байна.

##### 1.3.1. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын тайлан мэдээг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс сумдаас авч нэгтгэсэн боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хийгдээгүй байна.

###### 1.3.1.1. Аймаг, сумдын ИТХ 2017 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьсан байна.<sup>8</sup>

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 22-ны тогтоолоор хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын төлөвлөлт, гүйцэтгэл, чанарт хяналт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгсөн байна. Үүний дагуу Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 22-ны хуралдаанаар Хархорин, Нарийнтээл, Бүрд, Богд сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын үр дүнг хэлэлцэж хийгдэж буй ажлын чанарт анхаарч, гэрээний хугацаанд дуусгах үүрэг даалгавар өгч ажилласан байна.

###### 1.3.1.2. Аймгийн ЗД-ын дэргэдэх СХДАХ-ээс 2017 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт хийгээгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба 2017 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийсэн баримт материал байхгүй байна.

##### 1.3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч ОНХС-ийн явцын тайлан, мэдээг сумдаас авч ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан боловч Сангийн яаманд тайлан мэдээ хүргүүлээгүй байна.

<sup>8</sup> “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9-ын 1-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд. тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

**1.3.2.1. Сумууд ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайлан, мэдээг аймгийн СТСХэлтэст хүргүүлсэн боловч аймгийн ЗДТГ-аас Сангийн яаманд хүргүүлсэн тайлан байхгүй байна.**

Сумууд хагас бүтэн жилээр ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т ирүүлсэн байна. Харин Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Хужирт сумууд мэдээ, тайлан ирүүлээгүй байна. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс Орон нутгийн хөгжлийн сангийн үр дүнгийн талаар Сангийн яаманд хүргүүлсэн тайлан байхгүй байна.

**1.3.2.2. Аймгийн ЗДТГ-аас ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланда дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулсан байна.**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс, Төрийн захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран сум, агентлагийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээг 3 зорилт бүлгийн 11 ажлын үзүүлэлтээр дүгнэж аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/48 дугаар захирамжаар тэргүүлсэн сум, агентлагийг урамшуулж, дутагдалтай хангалтгүй үнэлэгдсэнд гүйцэтгэл сайжруулах талаар үүрэг чиглэл өгсөн байна. Тус ажил дүгнэх үзүүлэлтийн Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаар Хархорин, Зүүнбаян-Улаан сумд хамгийн сайн үнэлгээ авсан бол Баянгол, Сант, Төгрөг сумд ажил сайжруулах, тааруу үнэлгээ авсан байна.

**1.3.2.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумдын санхүүгийн алба бүрэн хэрэгжүүлж төсөл арга хэмжээ тус бүрээр мэдээллийг байршуулж хэвшсэн байна.**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумдын санхүүгийн алба бүрэн хэрэгжүүлж төсөл арга хэмжээ тус бүрээр мэдээллийг байршуулж хэвшсэн байна.

**1.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-ын 12, 58 дугаар зүйлийн 4-ийн 3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.**

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-д “аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” ... 58 дугаар зүйлийн 58.2.12-д “мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах ... гэж заасан бөгөөд хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно. 60 дугаар зүйлийн 60.3.1-д орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ. Мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-д энэ хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй гэж зааж өгсөн байна.

Гэвч Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т аймгийн ОНХС-аар хийгдэх ажлын жагсаалтад “...гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах” талаар журамлагдаагүй байгаа нь төсвийн тухай хуультай зөрчилдөж байна гэж үзэж байна.

Мөн хуулийн 58 дугаар зүйлийн 58.4-д “сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ.”... 58 дугаар зүйлийн 58.4.3-д “сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшилийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлцуулалтыг хийх” гэж заасан байхад Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т хог зайлцуулалтыг хийх талаар сумдад хогийн төвлөрсөн цэг байгуулах, хог боловсруулах жижиг хэмжээний үйлдвэр байгуулах, хог тээврийн авто тээврийн хэрэгсэл нийлүүлэх гэж журамласан байх ба хог зайлцуулалтын хөлс, тээвэр, шатахууны зардлын талаар тусгагдаагүйгээс зөрчил үүсэж байна.

#### БҮЛЭГ-Хоёр.

**Сум хөгжүүлэх санд тавих хяналт хангалтгүй, хариуцлага тооцдоггүйгээс нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна.**

**2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хангалтгүй, зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн тооцож төвлөрүүлээгүй байна.**

**2.1.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.**

СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх ажил хангалтгүй байна. Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь зээл эзнээ олж өгөхгүй байгаатай холбоотой байна.

Аймгийн хэмжээгээр Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө 2017 оны эхэнд 676.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлангийн хугацаанд 2188.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 352 зээлдэгчид 1680.4 сая төгрөгийн зээл олгож, жилийн эцэст 2865.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацааны орлогын 1878.8 сая төгрөг нь зээлийн эргэн төлөлт, 109.8 сая төгрөг нь зээлийн хүүгээс, 17.7 сая төгрөг нь алдангийн орлого нийт 2188.7 сая төгрөгийн орлого орсон байна. СХС-ийн нийт авлага 2017 оны жилийн эцэст хэвийн 3298.2 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 2016.7 сая төгрөг, чанаргүй 47.0 сая төгрөг нийт 5362.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Аудитад хамрагдсан сумдын хугацаа хэтэрсэн авлагыг авч үзэхэд хамгийн их нь Арвайхээр сум 452.6 сая төгрөг, Баян-Өндөр сум хамгийн бага буюу 1.1 сая төгрөг байна. Сумдын хугацаа хэтэрсэн авлагыг графикаар харуулав.



Цаашид зээлийн хүүг зээлдэгчтэй байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу тооцон бүртгэж, хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд журмын дагуу алданги тооцох нь зүйтэй. Аудитын дүнгээс үзэхэд СХС-аас олгосон зээлийг гэрээний хугацаанд эргэн төвлөрүүлж жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах эх үүсвэрийг цаг тухай бүрд нь бүрдүүлж чадаагүй, зээлийн эргэн төлөлт удаашралтай байна.

Аудитаар гэрээний хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг нөхөн төлүүлж, зөрчлийг арилгуулахаар 2063.7 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Аудитад хамрагдсан сумдын СХС-д гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй нийт 2063.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг хугацаанд нь төвлөрүүлсэн бол дунджаар 5.0-20.0 сая төгрөгийн 115 төслийг эхлүүлэх буюу үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой бөгөөд энэ хэмжээгээр ажлын байр нэмэгдэх байсан байна.

СХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор тус бүр 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан байна. СХС-ийн журамд заагдсаны дагуу зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн 3 гишүүн нь иргэний төлөөлөл байна гэсэн боловч зарим суманд иргэний төлөөллөөс оруулалгүй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс оролцуулан зөвлөл байгуулсан байна.

#### **2.1.2. Зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн төвлөрүүлээгүй байна.**

Аудитаар сумдын СХС-аас олгосон зээлийн хүү, алдангийн тооцоопол, бүртгэлийг харьцуулж үзэхэд 2017 онд Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Баянгол, Гучин-Ус, Есөнзүйл, Элзийт, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан, Сант, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт,

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ  
САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Арвайхээр сумд огт алданги тооцоогүй, Баян-Өндөр, Бүрд, Богд, Хархорин сумд 1.3-7.1 сая төгрөгийн алданги тооцож авсан байна. Харин Гучин-Ус, Баянгол, Баруунбаян-Улаан зэрэг сумд журмын заалтаар алданги тооцох талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 1.7-д Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана”-д заасны дагуу алдангийг бүрэн тооцож аваагүй байна. Аудитын дүнгээс үзэхэд алдангийг үнэн зөв тооцох, гэрээний хугацаандаа зээлээ эргэн төлөөгүйгээс үүсэн алдангийн үр дагаврыг төсөл хэрэгжүүлэгчдэд ойлгуулж хамтарч ажиллах талаар СХС-ийн мэргэжилтэн тодорхой ажил зохион байгуулж ажиллаагүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч нар зээл, зээлийн хүүг гэрээний хугацаанд нь эргэн төлөхгүй байгаа нь нэг талаас СХС-ийн эх үүсвэр цаг тухайд нь бүрдэж дараагийн төслийг санхүүжүүлэх боломжийг алдагдуулах, нөгөө талаас зээлийн эргэн төлөлт хуримтлагдан, зээлдэгчдэд зээлийн дарамт учруулахыг аль аль талдаа ойлгож хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, төлбөр тооцоог яаралтай барагдуулах шаардлагатай байна.

Мөн зээлийн хүүг үнэн зөв тооцох, ажил хариуцсан албан тушаалтнуудын ажлын уялдааг сайжруулах, бүртгэл, судалгааг стандартын дагуу үнэн зөв гаргах шаардлагатай.


СХС-ийн зээлийн төлөлтийг 2011 оноос хойш олгосон зээлийн үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлтөд аudit хийхэд 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2 (сая төгрөгөөр)

№	Аймаг, сумын нэр	Нийт зээлийн үлдэгдэл	Үүнээс		
			Хэвийн	Хугацаа хэтрэлтэй	Чанаргүй зээл
1	Баян-Өндөр	193.6	192.5	1.1	0.0
2	Бүрд	132.2	69.7	62.5	0.0
3	Бат-Өлзий	232.0	121.3	87.6	23.1
4	Баруунбаян-Улаан	176.3	50.9	125.4	0.0
5	Баянгол	199.4	123.6	75.8	0.0
6	Гучин-Ус	178.0	115.8	62.2	0.0
7	Есөнзүйл	230.4	130.9	92.3	7.2
8	Өлзийт	164.7	95.1	59.3	10.3
9	Зүүнбаян-Улаан	114.2	39.9	67.9	6.4
10	Богд	210.4	148.7	61.7	0.0
11	Нарийнтээл	219.2	115.3	103.9	0.0
12	Сант	197.1	153.5	43.6	0.0
13	Тарагт	222.9	141.9	81.04	0.0
14	Төгрөг	207.4	118.8	88.6	0.0
15	Уянга	398.7	275.1	123.6	0.0
16	Хайрхандулаан	234.9	184.3	50.6	0.0
17	Хужирт	218.2	169.6	48.6	0.0

<b>18</b>	Хархорин	852.5	524.1	328.4	0.0
<b>19</b>	Арвайхээр	979.9	527.3	452.6	0.0
	<b>Аймгийн нийт дүн</b>	<b>5362.0</b>	<b>3298.2</b>	<b>2016.74</b>	<b>47</b>

Аймгийн хэмжээнд СХС-ийн хөрөнгийг хэрэгжиж эхэлснээс нь хойш өссөн дүнгээр тулган шалгахад 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 5362.0 сая төгрөгийн хэвийн зээл 3298.2 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 899 зээлдэгчийн 2016.7 сая төгрөг, 47.0 сая төгрөгийн чанаргүй зээл байна. Нийт олгосон 5362.0 сая төгрөгийн зээлээс 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл эзэлж байна.



## 2.2 Сум хөгжүүлэх сангаар нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна.

### 2.2.1 СХС-аас зээл олгох төсөл сонгон шалгаруулах зөвлөл ирүүлсэн төслийг нэг бүрчлэн хэлэлцэхгүйгээр шийдвэр гаргасан байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4.2 дахь “Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна” гэсэн заалтыг хангасан эсэх, иргэн зээлээр ямар үйл ажиллагаа эрхлэх талаар хэлэлцэхгүйгээр шийдвэр гарган зээл олгосон байна.

Богд сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөл 2017 оны 04 дүгээр сарын 24-нд хуралдан 23 төсөл ирүүлснийг хэлэлцүүлж, 11 төсөл сонгон шалгаруулсан байна. Үүнд иргэн Г.Батжаргалын “Дөхөм өгөөж” буудал төслийг хэлэлцээгүйгээр 5.0 сая төгрөгийн зээл олгохоор зөвлөлийн хурлын тэмдэглэлд шийдвэрлэсэн боловч Засаг даргын 2017 оны а/56 дугаар захирамжаар 6.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Баянгол сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 18 ны өдрийн А/89 дүгээр захирамжаар иргэн М.Мягмардоржийн гутал засвар төсөлд 2.0 сая төгрөг олгохоор шийдвэр гаргасан нь төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцээгүй төсөлд шийдвэр гарган зээл олгосон байна.

Баруунбаян-Улаан сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөл 2017 оны 05 дугаар сарын 03 ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд иргэн Б.Эрдэнэтогтохын Уран шаглаа, М.Бундууламын гоо сайхан гэсэн төслүүдийг дэмжихгүй, Б.Сүрэнхүүгийн Хас хэлхээ төслийг дэмжихээр хэлэлцсэн боловч иргэн Т.Наран, А.Баяртогтох, Ц.Одончимэг нарын газар тариалан, Д.Даваанямын үхэр өсгөх, Ж.Дуламсүрэнгийн гоо сайхан төслүүдийг хэлэлцэхгүйгээр 5 төсөлд 40.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэн захирамж гаргасан байна.

Хайрхандулаан сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар 37 иргэнд 101.0 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэхдээ төслүүдийг нэг бүрчлэн хэлэлцээгүй хурлын шийдвэр, Засаг даргын захирамж, шилжүүлсэн мөнгөн дүн зөрүүтэй нь ажлын хариуцлага хангалтгүй байгааг харуулж байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4.4-д “Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөл иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн төсөл мөн журмын 4.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах бөгөөд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар зохих шийдвэрийг гаргана. Зөвлөл тухайн төслийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан тохиолдолд санапаа ажлын 3 хоногийн дотор тухайн сумын Засаг даргад хүргүүлнэ. Зөвлөлийн хуралд нийт гишүүдийн гуравны хоёр оролцсон тохиолдолд хурлын ирц бүрдсэн гэж үзнэ”, 4.5-д “Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн сумын Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## 2.2.2 Зээлийн гэрээг батлагдсан загвараар байгуулсан байна.

Сумууд ихэвчлэн Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 72 тоот тушаалаар батлагдсан гэрээний загвараар гэрээг хийж байгуулсан байна.

Баянгол сумын зээлдэгч Б.Отгонжаргал, Төгрөг сумын зээлдэгч Б.Амаржаргал, С.Эрдэнэтоогох, Б.Оюунбаатар нарын барьцаа хөрөнгө Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 3.5.4<sup>9</sup>-д заасан шаардлагыг хангахгүй байна. Мөн Баянгол сумын зээлдэгч Ч.Баянмөнхийн гэрээнд барьцаа хөрөнгө байхгүй байна.

## 2.2.3 Зээлийг төслийн зориулалтаар ашиглаагүйгээс бодит ажлын байр нэмэгдсэн үр дүн гарагүй байна.

Баянгол сумын 2017 онд зээл авсан зээлдэгчдийн зээлийн зориулалтыг газар дээр нь шалгалт хийхэд иргэн Ч.Баянмөнхийн хээлтүүлэгч мал маллах 11.0 сая төгрөгийн төслөөс бусад 37.8 сая төгрөгийн 5 төсөл тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байлаа. Гэвч 2017 онд Баянгол сум 6 төсөлд зээл олгож 16 ажлын байр нэмэгдүүлсэн талаар СХС-ийн тайландаа тусгасан байна.

Төгрөг сумын 2017 онд олгосон 67.0 сая төгрөгийн төслийн 15 зээлдэгч тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байна. Гэвч 15 төсөлд зээл олгосноор 7 ажлын байр шинээр нэмэгдэж, 13 ажлын байр хадгалагдсан байна гэж ажлын байр нэмэгдүүлсэн талаар сумууд худал мэдээ, тайлан гаргасан байна. Эдгээр нь СХС-аас авсан зээлийг гэрээнд заасан

<sup>9</sup> Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол /Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам/-ын 3.5.4-д Энэ журмын 3.5.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаанд бариулах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх;

зориулалтын дагуу ашиглаагүй иргэдэд Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 6<sup>10</sup>-д заасны дагуу хариуцлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Арвайхээр сумын СХС-аас тус санг хариуцсан мэргэжилтний цалинд 6.3 сая төгрөг зарцуулсан, Өлзийт сум 0.5 сая төгрөгийн Санхүү хяналт дотоод аудитын хэлтсийн тавьсан актын төлбөрийг шилжүүлсэн байна. Хужирт сумын Засаг дарга Хархорин сум дахь сум дундын шүүхэд нэхэмжлэх гаргаж 2013 онд зээл авсан 8 иргэний зээлийг эргэн төлүүлэхэд 1.4 сая төгрөг, Баруунбаян-Улаан сум 0.2 сая төгрөг, нийт 1.6 сая төгрөгийг ШШГАлбандаа зээл төлүүлэхээр шийдвэр гаргуулахтай холбоотой зардалд шилжүүлсэн нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1.9<sup>11</sup>-д “Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **2.3 Сум хөгжүүлэх санд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулсан ч зарим сумд хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.**

#### **2.3.1 Сум хөгжүүлэх сангийн үр дүнд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.**

2017 онд СХСанд Арвайхээр, Бүрд, Өлзийт, Баянгол, Богд, Баруунбаян-Улаан Нарийнтээл, Хайрхандулаан, Хархорин сумдын хяналтын зөвлөл тодорхой хяналт тавьж ажиллаагүй байна.

Харин Сант, Уянга, Тарагт сумдын хяналтын зөвлөл хяналт тавьж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайланд тусгасан байна.

Сумууд Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 5.3.2<sup>12</sup>-д зааснаар улирал бүр хяналт шалгалт хийж, сумын нийт иргэдэд танилцуулж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна.

<sup>10</sup> Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол /Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам/-ын 6.1. Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиглаагүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд сангаас дахин зээл олгохгүй.

<sup>11</sup> Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол /Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам/-ын 1.5. Сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг тухайн сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайланд тусгана.

1.8. Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

<sup>12</sup> Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол /Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам/-ын 1.5. Сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг тухайн сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайланд тусгана.

1.8. Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

Баянгол сумын санхүүгийн албаны дарга 2011-2017 оны 39 зээлдэгчийг хамруулан шалгалт хийж, ЖДҮХариуцсан мэргэжилтэнд ажил сайжруулах зөвлөмж өгсөн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ирүүлсэн 2018 оны 09 дүгээр сарын 26 ны өдрийн 53 тоот албан бичгээр Сум хөгжүүлэх сангийн 2014, 2015 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгдсэн ажлын тайланг ирүүлсэн байна. Мөн уг хяналт шалгалтын мөрөөр 2018 оны 03 дугаар сарын 20 -ны байдлаар сумдаас авсан мэдээгээр 5439.9 сая төгрөгийн СХС-ийн эх үүсвэртэй, хугацаа хэтэрсэн 911 зээлдэгчийн 1865.4 сая төгрөгийн зээл байна гэсэн тайлан ирүүлсэн байна.

Орон нутагт 2017 оны СХС-ийн үйл ажиллагаанд бусад шатны байгууллагаас хяналт тавьсан ажлын баримт байхгүй байна.

### 2.3.2 Сум хөгжүүлэх сангийн тайлан, мэдээ зөрүүтэй байна.

Сумдын ЖДҮХМэргэжилтэн СХСанг хариуцан ажилладаг байна. СХС-ийн зээлийн эргэн төлөлт, зарцуулалттай холбоотой мэдээг улирал бүр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт нэгтгүүлдэг боловч мэдээнд зээлийн хуваарь, эргэн төлөлт, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан байна.

Зарим сумдын санхүүгийн албаны дарга хяналт тавьж давхар зээл төлөлтийн мэдээ хөтөлдөг бол Уянга, Баруунбаян-Улаан сумд СХС-ийн дансны хуулгыг ЖДҮХМэргэжилтэнд өгч мэдээг гаргадаг тул зээлийн эргэн төлөлтийн мэдээ буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

Төсвийн тухай хуульд зааснаар СХС-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн үлдэгдэлтэй, СХС-ийн авлага, эргэн төлөлт, жилийн эцэст аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт гаргаж нэгтгүүлдэг судалгааг тулгаж үзэхэд хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

### 2.3.3 Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлдэгчид хариуцлага тооцсон арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Сумдын СХС-ийн зөвлөлийн дарга, хариуцсан мэргэжилтнүүд 2017 онд хугацаа хэтэрсэн зээлдэгчид мэдэгдэл хүргүүлж ажилласан ч шүүхэд шилжүүлсэн, хариуцлага тооцсон арга хэмжээ хангалтгүйгээс 899 зээлдэгчийн 2063.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна.

**2.4. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам төдийлөн мөрдөгдөхгүй, сангийн үйл ажиллагаа нь зорилго, зорилтдоо хүрэхгүй байгаа нь хууль, эрх зүйн асуудлыг өөрчлөх шаардлагатайг харуулж байна.**

Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь зээл хүсэгчийн ирүүлсэн төсөлд эдийн засгийн тооцоо, судалгаа хийж, учирч болзошгүй эрсдэлийг тооцоолж, зах зээлийг бүрэн судлаагүйгээс төдийлөн сайн төслийг сонгон шалгаруулж чадахгүй байна. Энэ нь сумын хөгжлийн үндсэн чиглэл, жижиг, дунд үйлдвэрлэлийг

хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүйтэй холбоотой байна. Мөн төлбөрийн чадваргүй иргэдийг төсөлд сонгон шалгаруулж байгаа нь төсөл хэрэгжихгүй байх, олгосон зээлийг зориулалт бусаар зарцуулах, хэрэглээний зээл байдлаар ашиглах явдал их байна.

Одоо мөрдөгдөж байгаа Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралт “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн талаар нарийвчлан зааж өгөөгүй, хариуцлага тооцох талаар тодорхой заалт байхгүйгээс зээлийн эргэн төлөлт удаашралтай, хугацаа хэтэрсэн зээл, чанаргүй зээл ихтэй байна. Иймд СХС-ийн зээлтэй холбоотой хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Цаашид СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан зөрчлийн талаар хариуцлага сайжруулах арга хэмжээ авах, тухайн хууль журамд нарийн тусгаж, холбогдох албан тушаалтанд ногдуулах хариуцлагын асуудлыг тодорхой зааж өгөх хэрэгтэй байна.

СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь төслүүдийг сонгон шалгаруулж, шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг сумын Засаг дарга нар нь захирамж гарган гэрээ байгуулан, санхүүжилтийг олгодог байна.


СХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл хэрэгжихгүй, зориулалт бусаар ашиглагдаж байгаа нь төсөл сонгон шалгаруулалт оновчгүй, төсөл хэрэгжүүлэхэд хангалттай эх үүсвэр болж чадахгүй байгаатай холбоотой байна.

Аудитын явцад сумдаас сангийн хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн ажлын тайлан болон холбогдох баримт материалыг шаардсан боловч ихэнх сумд гаргаж өгөөгүй нь хяналт хийгдээгүй гэж дүгнэхэд хүрч байна. Хяналтын орон тооны бус зөвлөл нь журмын дагуу ажиллахгүй байгаа нь сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, зарцуулалтын талаар дээрх бүлгүүдэд дурдагдсан зөрчлүүд үүсэх гол нөхцөл болж байна. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах хяналт тавих журмын 6.2 /Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулах, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ/-д заасны дагуу үүргээ биелүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. СХС-ийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, холбогдох журмыг хэрэгжүүлээгүй ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээг авч ажиллах, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.


СХС-ийн үйл ажиллагааг тайлагнах мэдээ судалгаа хангалтгүй, хяналт тавьдаггүйгээс зээлийг зориулалт бусаар ашиглах, хугацаа хэтэрсэн зээлийн авлага үүсэх нөхцөл бүрдэж байна.

СХС-ийн талаар иргэдээс санал асуулгын дүнг дараах графикт харуулав.

Та ямар чиглэлийн бизнес эрхэлдэг вэ?



ТА СУМ ХӨГЖҮҮЛЭХ  
САНГИЙН ТАЛААР ХЭР  
МЭДЭЭЛЭЛТЭЙ ВЭ?





СХС-ийн талаар иргэдээс санал асуулгын дүнгээр Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтооплын 1.8 “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дунд хяналт тавих үйл ажиллагаанд зориулна” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

ТА СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН  
ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ  
ХААНААС АВСАН ВЭ?



Та Сум хөгжүүлэх сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн үү?





**БҮЛЭГ-Гурав.**

**Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.**

**3.1 Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, зарим албан шаардлага хэрэгжээгүй байна.**

**3.1.1 Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.**

Өмнөх оны аудитаар 9 зөвлөмж өгөгдөж бүрэн хэрэгжүүлсэн байна.

**3.1.2 Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт 3 суманд дутуу хэрэгжсэн байна. Тухайлбал:

Бүрд сумын Сургуулийн спорт залны засварын агааржуулалт хийгдээгүйгээс ханын шохой хууларсан, чанаргүй гүйцэтгэсэн 57.9 сая төгрөг, Есөнзүйл сумын СӨББ-ын цонх 5.0 сая төгрөгөөр сольсон ажил чанаргүй хийгдсэн ажлуудыг дахин засварлахаар албан шаардлага хүргүүлсэн, Арвайхээр сумын Ногоон байгууламж бүхий спорт, тоглоомын талбай байгуулах 8.4 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн ажилд албан шаардлага хүргүүлсэн боловч аудитаар газар дээр нь очиж үзэхэд албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, санхүүжилт олгосон, ажлыг чанартай гүйцэтгүүлэх арга хэмжээ авч аваагүй байна.

Дээрх албан шаардлага биелүүлээгүй 3 сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нарт Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, 28 дугаар зүйлийн 28.2.2-д “төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд” гэсэн заалтыг үндэслэн хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргад саналыг хүргүүллээ.

Бусад сумд, аймгийн ОНХСан хариуцсан холбогдох албан тушаалтан албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

**3.2 СХС-ИЙН ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

**3.2.1 ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ, АКТ, АЛБАН ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.**

Сум хөгжүүлэх сангийн 2013 оны хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, түүний үр дүнд 2014 оны 06 дугаар сард Есөнзүйл, Өлзийт, Баян-Өндөр, Сант, Баянгол, Хайрхандулаан, Нарийнтээл, Баруунбаян-Улаан сумдыг хамруулан аудит хийж, “Сум хөгжүүлэх сангийн 2013 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт шалгалт хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа ч төлөвлөлт, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн үйл ажиллагаа журмын дагуу явагдаагүй байна” гэсэн дүгнэлт өгч 162.8 сая төгрөгийн үр өгөөж тооцон, 96.9 сая төгрөгийн төлбөрийн акт тавьж, 206.7 сая төгрөгийн албан шаардлага, 11 төрлийн зөвлөмж өгч хэрэгжүүлсэн байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өгөгдсөн 3 төрлийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## Дүгнэлт

### БҮЛЭГ - Нэг.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилан зарцуулсан ч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл, хувь хэмжээгээр төлөвлөсөн байна.

1.1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг орон нутагт үзэх боломжгүй байна.

1.1.1.2. ОНХС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн эсэхийг орон нутагт үзэх боломжгүй байна.

1.1.1.3. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр төлөвлөсөн байна.

1.1.2 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг болон эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд зааснаар бүрдүүлсэн байна.

1.1.2.1 ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд зааснаар бүрдүүлсэн байна.

1.1.2.2 Аймаг сумын ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59.1-д зааснаар бүрдүүлсэн байна.

1.1.3 ОНХСанг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

1.1.3.1 Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

1.1.3.2 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилсан байна.

1.1.3.3 ОНХС болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгох

1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд зааснаар зарцуулсан байна.

1.2.1 Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталж ажилласан байна.

1.2.1.1 Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.2.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх TAX-г иргэдээд нээлттэй хэлэлцүүлэн санал авч байгаа боловч төсвийн хүрэлцээ багассан, урд онуудын саналын эрэмбэлэлтээр хийгдээгүй ажлууд хойшилсноос иргэдээс авах санал багассан байна.

1.2.1.3 Аймаг, сумдын Засаг дарга баг, хороодоос ирсэн саналыг хууль тогтоомжид тавьсан шаардлагын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгасан байна.

1.2.1.4 "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан TAX-г хэрэгжүүлсэн байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан байна.

1.2.2.1. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

1.2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас тавьж, Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс, сумдын төрийн сангууд төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгож ирсэн байна.

1.2.2.3. ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулжээ.

1.2.2.4. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланда тусгасан байна.

1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавиагүй, Сангийн яаманд үр дүнгийн тайланг хүргүүлээгүй байна.

1.3.1. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын тайлан мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс сумдаас авч нэгтгэсэн боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хийгдээгүй байна.

1.3.1.1. Аймаг, сумдын ИТХ 2017 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьсан байна.<sup>13</sup>

1.3.1.2. Аймгийн ЗД-ын дэргэдэх СХДАХ-ээс 2017 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт хийгээгүй байна.

1.3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч ОНХС-ийн явцын тайлан, мэдээг сумдаас авч ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан боловч Сангийн яаманд тайлан мэдээ хүргүүлээгүй байна.

1.3.2.1. Сумдууд ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайлан, мэдээг аймгийн СТСХэлтэст хүргүүлсэн боловч аймгийн ЗДТГ-аас Сангийн яаманд хүргүүлсэн тайлан байхгүй байна.

1.3.2.2. Аймгийн ЗДТГ-аас ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланда дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулсан байна.

1.3.2.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумдын санхүүгийн алба бүрэн хэрэгжүүлж төсөл арга хэмжээ тус бүрээр мэдээллийг байршуулж хэвшсэн байна.

1.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-ын 12, 58 дугаар зүйлийн 4-ийн 3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.

### БҮЛЭГ-Хоёр.

Сум хөгжүүлэх сангийн нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байхад хяналт хангалтгүй, хариуцлага тооцоогүй байна.

2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хангалтгүй, зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн тооцож төвлөрүүлээгүй байна.

2.1.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

2.1.2. Зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.2 Сум хөгжүүлэх сангаар нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байна.

2.2.1 СХС-аас зээл олгох төсөл сонгон шалгаруулах зөвлөл ирүүлсэн төслийг нэг бүрчлэн хэлэлцэхгүйгээр шийдвэр гаргасан байна.

2.2.2 Зээлийн гэрээг батлагдсан загвараар байгуулсан байна.

2.2.3 Зээлийг төслийн зориулалтаар ашиглаагүйгээс бодит ажлын байр нэмэгдсэн үр дүн гараагүй байна.

2.3 Сум хөгжүүлэх санд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулсан ч зарим сумд хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.

<sup>13</sup> “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9-ын 1-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд. тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

2.3.1 Сум хөгжүүлэх сангийн үр дүнд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.2 Сум хөгжүүлэх сангийн тайлан, мэдээ зөрүүтэй байна.

2.3.3 Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлдэгчид хариуцлага тооцсон арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.4. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам төдийлөн мөрдөгдөхгүй, сангийн үйл ажиллагана нь зорилго, зорилтдоо хүрэхгүй, цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд эрх зүйн асуудлыг өөрчлөх шаардлагатай байна.

БҮЛЭГ- Гурав.

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.1 Өмнөх оны орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, зарим албан шаардлага хэрэгжээгүй байна.

3.1.1 Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.1.2 Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.2 Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.2.1 Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

## Зөвлөмж

### Аймгийн Засаг дарга Г.Ганболдод

- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах.
- Журмын дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүн, зарцуулалтад ЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хяналт тавьж, жилийн эцэст тайлан гаргаж байх

### Сумдын Засаг дарга нарт

- Сумууд СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөлт, бүрдүүлэлтийг хууль, журмын дагуу хугацаанд нь төвлөрүүлж байх.
- Зөвлөлийн гишүүд төсөл сонгон шалгаруулахдаа үйл ажиллагаа явуулах ажлын байрыг сайн судалж олгох.
- СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр ирүүлсэн төсөл бүрийг журамд заасан шалгуураар нэг бүрчлэн хэлэлцэн шийдвэрлэж байх.
- Сумдын СХС-ийн зээл хариуцсан мэргэжилтнүүдийн ажил дүгнэх үзүүлэлтэд СХС-ийн эргэн төлөлтийн талаар оруулж, ажлын хариуцлагыг сайжруулах.
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээлдэгчид хууль, журмын дагуу алданги тооцож байх.

### Баянгол, Төгрөг сумдын Засаг дарга нарт

- Журмын шаардлага хангасан үнэлгээтэй барьцаа хөрөнгийн гэрээг байгуулж байх.

### Сумдын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүдэд

- 2011 оноос олгосон зээл тус бүрээр мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж программд оруулах

АУДИТИН ТАЙЛАНГ ХЯНАСАН:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТИН МЕНЕЖЕР

Л.ЛАМААЧИН  
Д.ГАНСҮХ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР Ц.ОТГОННЯМ  
АУДИТОР П.ХОРЛООСҮРЭН

Холбогдох байгууллагын санал



62173 Арвайхэр, Өвөрхангай аймаг.

Утас: 7032 2073

2018. 11. 29 № 10390

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Өвөрхангай Аймаг дахь төрийн  
аудитын газарт

Өвөрхангай Аймгийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайланийн төсөлтэй танилцлаа. Нийцлийн аудитын тайландаа өгөх санал байхгүй байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Д.НЭМЭХБАЯР

019301095

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ  
САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
**ХҮНС, ХӨДӨӨ ЛЖ АХУЙН ГАЗАР**

62173 Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг,  
Утас: 7032 3713, Факс: (976) 7032 2267,  
<http://mofa.gov.mn/ovorhangai>


2018. 11. 28 № 433

тавдай 2018. 11. 28 № 429 -т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТИН ГАЗАРТ

2017 оны Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тайлантай холбогдолтой санал болон тайлбар байхгүй болно.



ДАРГА 15.11.2018  
D:\IALBAN\TOOT\Aa\Alban.tdr\A5-2018.docx

Тайлан баталгаажуулсан тушаал



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 29-өдөр

Дутаар *А/146*

Арвайхээр

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”, 2017 оны А/188 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дунд хийсэн нийцлийн аудитын тайлан /УАГ-НАГ/2018/НА-02/-г баталгаажуулсугай.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дунд өгөгдсөн албан шаардлагыг нэгдүгээр хавсралтаар, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дунд өгөгдсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн ИТХурлын дарга /А.Ишдорж/, аймгийн Засаг дарга /Г.Ганболд/, аймгийн ХХААГазар, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биөлэлтийг 2019 оны 8 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дунг 2019 оны 03 дугаар улиралд багтаан удирдлагын зөвлөлд танилцуулахыг аудитын менежер /Д.Гансүх/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Л.Ламаачин* Л.ЛАМААЧИН

450114

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр сарын  
29-ний өдрийн А/22 тушаалын нэгдүгээр хавсралт

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгийг холбогдох хууль, журмыг мөрдөлгүйгээр  
зориулалт бусаар зарцуулсан, бүртгэл, тайланд тусгаагүй, эрэмбэлэгдээгүй зөрчилд өгсөн  
албан шаардлагын жагсаалт

/сая.төгрөг/

Д.д	Аймаг, сумдын нэр	Албан шаардлагын дүн	Зөрчлийн утга
6	Бүрд	2.0	Зориулалт бусаар цагдаад мотоцикл авах зардалд 2.0 сая төгрөг зарцуулсан.
7	Төгрөг	1.6	Ахмадын жилийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах зардалд 0.5 сая төгрөгийг медалийн үнэд. ЗДТГ-ын барилгын их засварын ажлын зураг төсвийн үнэд 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
8	Арвайхээр сумын ТҮК	10.7	Аймгийн төвийн наадмын талбайн засварын ажлыг шууд гэрээ байгуулан ажил гүйцэтгэсэн байна
9	Богд	44.0	Смарт зоос ХХК-тай хуурай сүүний үйлдвэрийн барилга барих ажлыг шууд гэрээ байгуулан 44.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна
10	Нарийнтээл	10.1	Барилгын засварын ажлыг 10.1 сая төгрөгийн санхүүжилт гэрээ байгуулахаас өмнө олгосон байна.
11	Өвөрхангай	867.0	Ахмадын өргөөний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж иргэдийн саналд эрэмбэлэгдээгүй ажлыг 867.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.
12	Өвөрхангай	851.5	Арвайхээр хотын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 851.5 сая төгрөгийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтанд оруулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй байна.
	ДҮН	1786.9	

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/22 тушаалын хоёрдугаар хавсралт

Сумдын СХС-ийн хөрөнгийг холбогдох хууль, журмыг мөрдөлгүйгээр хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, зориулалт бэсаар зарцуулсан албан шаардлагын жагсаалт

/сая.төгрөг/

Д.д	Аймаг, сумдын нэр	Албан шаардлагын дүн	Зөрчлийн утга
1	Баян-Өндөр сум	1.1	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
2	Бүрд сум	62.5	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 22 зээлдэгчийн 62.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
3	Бат-Өлзий сум	110.7	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 59 зээлдэгчийн 110.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
4	Баруунбаян-Улаан сум	125.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 51 зээлдэгчийн 125.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна, аймгийн ШШГАлбанд нэхэмжлэх гаргаж 0.2 сая төгрөг зарцуулсан.
5	Баянгол сум	113.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 23 зээлдэгчийн 75.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. Мөн 2017 онд олгосон 37.8 сая төгрөгийн 5 төсөл тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байна.
6	Гучин-Үс сум	62.2	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 19 зээлдэгчийн 62.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна
7	Есөнзүйл сум	99.5	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 78 зээлдэгчийн 99.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
8	Өлзийт сум	70.1	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 50 зээлдэгчийн 69.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. 0.5 сая төгрөгийн санхүү хяналт дотоод аудитын хэлтсийн тавьсан актны төлбөрийг шилжүүлсэн байна.
9	Зүүнбаян-Улаан сум	74.3	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 24 зээлдэгчийн 74.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
10	Богд сум	62.7	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 24 зээлдэгчийн 61.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. Мөн

			сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрээс илүү 1.0 сая төгрөгийн зээл олгосон байна.
11	Нарийнтээл сум	103.9	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 72 зээлдэгчийн 103.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
12	Сант сум	43.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 35 зээлдэгчийн 43.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
13	Тарагт сум	81.04	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 35 зээлдэгчийн 81.04 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
14	Төгрөг сум	155.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 41 зээлдэгчийн 88.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. Мөн 2017 онд олгосон 67.0 сая төгрөгийн төслийн 15 зээлдэгч тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байна.
15	Уянга сум	123.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 74 зээлдэгчийн 123.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
16	Хайрхандулаан сум	50.6	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 37 зээлдэгчийн 50.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
17	Хужирт сум	50.0	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 24 зээлдэгчийн 48.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна, Хархорин сум дахь сум дундын ШШГАлбанд нэхэмжлэх гаргаж 2013 онд зээл авсан 8 иргэний зээлийг эргэн төлүүлэхэд 1.4 сая төгрөг зарцуулсан.
18	Хархорин сум	328.4	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 58 зээлдэгчийн 328.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.
19	Арвайхээр сум	458.9	СХСангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 159 зээлдэгчийн 452.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. Мөн СХС-аас тус санг хариуцсан мэргэжилтний цалинг олгож, 6.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
	Дүн	2177.9	